



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2023.03.24 № 01/680
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Улсын авто замын сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын авто замын сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Зам, тээврийн сайдын 2015 оны 130 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалаар Олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс зам ашигласны төлбөр авах тухай журмын дагуу төлбөр хураах үйл ажиллагааг зохион байгуулах ажлыг Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-т шилжүүлсэн. Төлбөр хураах 30 цэгээр дамжуулан тайлант онд 13,545,476.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн нь төлөвлөснөөс 11,454,707.3 мянган төгрөгийг дутуу, өмнөх оноос 35.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Тус сангийн үйл ажиллагааны урсгал зардлыг Зам, тээврийн хөгжлийн төвөөр дамжуулан зарцуулдаг, тайлант оноос эхлэн тусдаа аудитын дүгнэлт гаргаж байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд улсын төсвөөс 42,100,000.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагаанаас 25,000,000.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, нийт 67,100,000.0 мянган төгрөгийг урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 42,100,000.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагаанаас 13,545,476.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 50,710,557.2 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 4,910,949.5 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулж, улсын төсөвт 17,096.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, 23,988.9 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САРАНСҮХ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 24 № 739/А0170083
СНАГ-2023/06/НА-СТА-ЗГХ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын авто замын сангийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Авто замын тухай хуульд заасан "Авто замын бүртгэл, мэдээллийн сан"-д заавал тусгавал зохих дараах мэдээлэл дутуу байна. Тухайлбал: Тусгай зориулалтын зам, асфальтан замын элэгдэл хорогдол, авто зам, замын байгууламжид хийсэн засварын мэдээлэл, авто зам, замын байгууламжид гарсан эвдрэл, ослын талаарх мэдээллүүд огт бүртгэлгүй, зарим асфальтан замын өртгийг бүртгээгүй байна.

Энэ нь Авто замын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 "авто замын бүртгэл, мэдээллийн сан" гэж авто зам, замын байгууламжийн үндсэн өгөгдөл, өртөг болон авто зам, замын байгууламжтай холбоотой бусад мэдээллийг агуулсан цахим санг", 27.1.1 "техникийн болон ашиглалтын үзүүлэлт", 27.1.2 "хүчин чадал, зэрэглэл, төлөв байдал", 27.1.3 "төсөвт өртөг, элэгдэл, хорогдлын бүртгэл, мэдээлэл", 27.1.4 "ашиглалтад орсон хугацаа", 27.1.5 "авто зам, замын байгууламжид хийсэн засварын мэдээлэл", 27.1.6 "авто зам, замын байгууламжид гарсан эвдрэл, зам, тээврийн ослын мэдээ", 27.1.7 "авто зам, замын байгууламжийг барьж байгуулсан болон арчлалт, засвар хийсэн байгууллагын талаарх мэдээлэл", 27.1.8 "бусад" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авто зам, замын байгууламжийн бүртгэл мэдээллийн санг эрхлэн хөтөлж, нэгдсэн санг бүрдүүлж ажиллах, албан шаардлагын хэрэгжилтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Батболд/, Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Сугармаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
О.БАЯРМАА
Н.НЯМСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2023\0324 SNAG-8.Docx

0001081537



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 24 № 440/АД170083
СНАГ-2023)06)НА-СТА-ЗГТС

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын авто замын сангийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар Улсын авто замын сангийн хөрөнгийн зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагааны хяналт, шалгалт болон авто зам, замын байгууламж барих, засварлах, арчлах, зураг төсөл боловсруулах, техник, технологийн хяналттай холбоотой норм, нормативын дагуу явцын хяналтыг тогтмол хийгээгүйгээс зам арчлалын компаниудтай байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний хэрэгжилт хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн ерөнхийлөн захирагч нь Авто замын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 "Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 10.1.6 "Авто зам, замын байгууламж барих, засварлах, арчлах, зураг төсөл боловсруулах, техник, технологийн хяналттай холбоотой норм, норматив, техникийн баримт бичиг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авто зам, замын байгууламж барих, засварлах, арчлах, зураг төсөл боловсруулах, техник, технологийн хяналттай холбоотой норм, нормативын дагуу явцын хяналт тогтмол хийх, хэрэгжилтэд нь хяналт тавих, албан шаардлагын хэрэгжилтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Батболд/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дарга /А.Мөнхбат/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
О.БАЯРМАА
Н.НЯМСҮРЭН

0001081539



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 24 № 441/АМТ0083
СНАГ-2023/06/НА-СТА-ЗГТС

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын авто замын сангийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Азийн хөгжлийн банкны МОН-3129 зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслийн хүрээнд нийлүүлсэн 4 төрлийн тусгай зориулалтын авто замын засвар, арчлалтын техникийг үндсэн хөрөнгөд бүртгээгүй, тушаал шийдвэрт хөрөнгийн өртөг, зээлийн хүү, ханшийн алдагдлын талаарх мэдээлэл тодорхойгүй, Зам, тээврийн хөгжлийн яамны 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 05/601 дугаар албан бичгийн хэрэгжилтийг хангуулж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2 "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дугаар тогтоолын 4.1.3 "Энэ журмын 4.1.1-д "заасан хөрөнгийг хүлээн авч буй хуулийн этгээд тухайн иргэн, хуулийн этгээдийн зөвшөөрлийг албан ёсоор авч үндсэн болон эргэлтийн хөрөнгөөр нь ангилан, ашиглах хугацаа, чанар байдлыг нь харгалзан ашигласан хугацааны элэгдэл, хорогдлын шимтгэлийг тооцож данс бүртгэлдээ тусгана" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төслийн хүрээнд нийлүүлсэн хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгэж, албан шаардлагын хэрэгжилтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга /Ч.Ренчиндамба/, Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Сугармаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
О.БАЯРМАА
Н.НЯМСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2023\0324 SNAG-8.Docx

0001081547



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 24

№ 4НЭ/А0140083

Улаанбаатар хот

СНАГ-2023/06/НА-СТА-3ГТ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын авто замын сангийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Олон улс, улсын чанартай авто замын арчлалт, засварын санхүүжилтийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/147 дугаар тушаалаар тусгай замын жагсаалтад оруулсан Газрын тос боловсруулах үйлдвэрийг Сайншанд хоттой холбох 17.5 км хүнд даацын хатуу хучилттай Т08 дугаартай замын арчлалт, засварт 35,700,000.00 /Гучин таван сая долоон зуун мянган/ төгрөгийг олгосон байна.

Энэ нь Авто замын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 "тусгай зориулалтын авто зам", 17 дугаар зүйлийн 17.4 "Тусгай зориулалтын авто замын хөрөнгө оруулагч нь авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр авто замыг эзэмшиж болно", 17.5 "Энэ хуулийн 17.4-т заасан гэрээний үндсэн дээр авто замыг эзэмшигч нь өөрийн эзэмшлийн авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтыг хариуцна", 24 дүгээр зүйлийн 24.3 "Улсын авто замын сангийн хөрөнгөөр олон улс, улсын чанартай авто замын, нийслэл, орон нутгийн замын сангийн хөрөнгөөр нийслэл, орон нутгийн чанартай авто замын арчлалт, засварын ажлыг тус тус санхүүжүүлнэ", 24.8 "Авто замын сангийн хөрөнгийг энэ хуулийн 24.3, 24.4, 24.5-д зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Олон улс, улсын чанартай авто замын арчлалт, засварын санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах, албан шаардлагын хэрэгжилтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Батболд/, Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Сугармаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
О.БАЯРМАА
Н.НЯМСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2023\0324 SNAG-8.Docx

0001081545